

2024 оны Ариун сүм, гэр бүлийн түүхийн удирдлагын зааварчилгаа

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ

Удирдагчдын хувиар цугларч, Ариун сүм, гэр бүлийн түүхийн удирдлагын зааварчилгааг үзэж байгаа та бүхэнд баярлалаа. Энэхүү захиасыг үзэх явцдаа та бүхнийг хамтдаа зөвлөлдөхөд урьж байна. Дараах асуултуудыг хөтөч болгон ашиглах эсвэл зөвлөлийнхөө хэрэгцээнд тааруулан өөрчилнө үү. [“Үр дүнтэй зөвлөлийн зарчим”](#) (Ерөнхий гарын авлага: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйлчлэх нь, 4.4)-ыг үзнэ үү.

1. Энэхүү зааварчилгааг сонсож байх үед Сүнс танд юу заасан бэ?
2. Бид хэнд эерэг туршлага үлдээсэн анх удаагийн төлөөлөн гүйцэтгэх баптисм, гишүүний баталгаа хийхэд нь тусалж болох вэ? Тэдний нэрсийг жагсаагаад үзээрэй.
3. Бид хэрхэн Сүмийн удирдагч бүрд Ёслолууд нь бэлэн болон Гэр бүлийн нэрийн тусламжийг ашиглахад туслах вэ?

Та хүмүүст ариун сүмд анх удаа орж, эерэг туршлага авахад туслахын тулд дараах эх сурвалжуудын аль нь тустай байж болох талаар эргэцүүлнэ үү. Үүнд:

- FamilySearch аккаунт үүсгэх
- Ариун сүм, гэр бүлийн түүхийн зөвлөхтэй уулзаж тусламж авах
- Вэбсайтаас туслагч дүрсийг нэмэх
- FamilySearch.org дээрээс Туслах эх сурвалжийг үзэх 
- Удирдагч, бичиг хэргийн ажилтны мэдээллийн сан дахь Гэр бүлийн нэрийн тусламжийг орж үзэх

“Шинэ хөрвөгчид ... Их Эзэний өргөөнд орох замыг олоход нь туслах бүхий л хичээл зүтгэл, өчүүхэн хүчин чармайлт бүр зөвхөн тэр хүнийг адислаад зогсохгүй таныг мөн адислах болно гэдгийг би амлаж байна. Энэ нь тойргийн тань гишүүдийг адисална. Сүмийн шинэ гишүүдтэй хамт ариун сүмийн эдгээр адислалыг хүртэх үед Есүс Христэд итгэх таны итгэл болон Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаарх ойлголт, хайр тань нэмэгдэх болно.

Ахлагч Нийл Л.Андэрсэн

